



**ХӨВСГӨЛ АЙМГИЙН
ЧАНДМАНЬ-ӨНДӨР СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ**

2024 оны 09 сарын 12 өдөр

Дугаар А/66

Хөхөө

□ Чонын үргээлэг, ав зохион байгуулах □
тухай

Монгол улсын Засаг захиргаа нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх заалт, Байгаль орчныг хамгаалах тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.2.2 дахь заалт, Амьтны тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.5.1, 35 дугаар зүйлийн 35.1 дэх заалт Байгалийн нөөц ашигласны төлбөрийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.3 дахь заалт, Байгаль орчин, аялал жуулчлалын сайдын 2024 оны А/376 дугаар тушаал, аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын ээлжит 25 дугаар хуралдааны 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдрийн 01 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын 2024 оны 07 дугаар сарын 01-ний өдрийн А/332 дугаар захирамжийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Сумын хэмжээнд хүн амын эрүүл мэнд, аюулгүй байдлыг хамгаалах, халдварт өвчний голомтыг эрүүлжүүлэх болон мал, гэрийн тэжээвэр амьтанд өвчин халдварлах, иргэн хуулийн этгээдэд хохирол учруулахаас сэрэмжлэх зорилгоор зарим амьтны тоо толгойг зохицуулах арга хэмжээ авах зорилгоор чонын үргээлэг, ав зохион байгуулах ажлыг 2024 оны 09 дүгээр сарын 20-ны өдрөөс 11 дүгээр сарын 25-ны өдрийг хүртэлх хугацаанд зохион байгуулсугай.

2. Аймгаас батлагдсан дээд хязгаар 35 тоо толгойд багтаан зөвшөөрлийг олгож, удирдлага зохион байгуулалтаар хангаж ажиллахыг Засаг даргын орлогч (З.Анхсанчир)-д үүрэг болгосугай.

3. Чонын үргээлэг, авыг заасан хугацаанд баг тус бүрт зохион байгуулж ажиллахыг багийн Засаг дарга нарт даалгасугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Ж.Баасанжав)-д үүрэг болгосугай.

ДАРГА

Л.ЭНХЖАРГАЛ